**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Номгон сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ӨМА-2022/10/НА-СТА-ТТ3**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.Umnugovi@audit.mn<br>Өмнөговь аймаг Даланзадгад сум<br>2022 он | Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр<br>Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn<br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Сүрэнжаргал<br>Утас: 70533552 Цахим хаяг: Surenjargald@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2022.03.24 № 269

танай ______________-ны №______________ -т

НОМГОН СУМЫН ЗАСАГ
ДАРГА С.ИДЭРСҮРЭН ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Номгон сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Номгон сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заавар дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С.ЦЭРЭНБАЯР

D:\2021 Он\Бичиг Хэрэг\Явсан Бичиг\2022-03-24 №269с

0180213

**Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд**

/сая төгрөгөөр/

| | Үзүүлэлт | |
|---|---|---|
| | Эргэлтийн хөрөнгийн дүн | 1,082.6 |
| | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 18,729.6 |
| | **Нийт хөрөнгийн дүн** | **19,812.2** |
| | Нийт өр төлбөрийн дүн | 1,785.8 |
| | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 18,026.4 |
| | **Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **19,812.2** |
| | Үйл ажиллагааны орлогын дүн | 8,466.6 |
| | Үйл ажиллагааны зардлын дүн | 3,519.1 |
| | **Үйл ажиллагааны үр дүн** | 4,947.5 |
| | Үйл ажиллагааны бус үр дүн | 456.8 |
| | **Үйл ажиллагааны нийт үр дүн** | **4,490.6** |
| **Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** | | |
| | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 11,348.2 |
| | Тайлант оны үр дүн | 2,187.5 |
| | **Эцсийн үлдэгдэл** | **13,535.7** |
| **Мөнгөн гүйлгээний тайлан** | | |
| | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн | 3,128.7 |
| | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн | 2,640.1 |
| | **Үйл ажиллагааны ЦМГ** | **488.6** |
| | **Хөрөнгө оруулалтын ЦМГ** | **-550.2** |
| | **Санхүүгийн ажиллагааны ЦМГ** | **61.6** |
| | **Нийт цэвэр мөнгөн гүйлгээ** | **61.6** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 649.1 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 587.5 |
| **Төсвийн гүйцэтгэлийн тайлан** | | |
| | **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | 2,520.2 |
| | Урсгал зардал | 2,006.7 |
| | Хөрөнгийн зардал | 513.5 |
| | **Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр** | |
| | Улсын төсвийн санхүүжилтээс | **1,354.5** |
| | Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс | **8.3** |
| | Орон нутгийн төсвийн санхүүжилтээс | **996.8** |

**Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Номгон сумын Засаг дарга нь эрхэм зорилго нь: “Иргэн төвтэй, хариуцлагатай, ухаалаг удирдлагаар хангаж хүний хөгжлөөр тэргүүлэгч сум болно” гэж тодорхойлжээ.

**Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

**Дөрөв. Аудитын гол асуудал**

Төсвийг бодитой төлөвлөж хууль, журмын дагуу зарцуулж байх.

**Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохих 175 мэдээллээс хугацаандаа оруулсан 151 мэдээлэл, хугацаа хоцроон оруулсан 22, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

**Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төсвийг бодитой төлөвлөж, хууль журмын зарцуулж байх.

**Долоо. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 1,577.8 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 1,577.8 сая төгрөгийг аудитын явцад залруулж, 2 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

**7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

**7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

/сая төгрөгөөр/

| № | | | Үүнээс |
|---|---|---|---|

| | Төсвийн захирагчийн ангилал | Нийт алдаа, зөрчлийн | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| 1 | ТШЗ | 4 | 1,577.8 | 2 | 1,577.8 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 0 |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | | | |
| | **НИЙТ** | 4 | 1,577.8 | 2 | 1,577.8 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 0 |